ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Дорнод аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: ДОА-2025/157/НА-СТА-ТШЗ**



| | |
|---|---|
| Цахим хуудас:<br>www.audit.mn<br>Чойбалсан хот<br>2025 он | Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,<br>Тэргүүлэх аудитор: Б.Болортуул<br>Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn<br>Аудитын менежер: И.Сэмжидмаа<br>Утас: 7058-4204, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Д.Нармандах<br>Утас: 7058-4207, Цахим хаяг:narmandakhd@audit.gov.mn |



Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**АГУУЛГА**

1. Хараат бус аудиторын дүгнэлт........................................................ 3-4

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл........................................................5-9

3. Аудитын илрүүлэлт ........................................................14

4. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл........................................................15

**ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын дээд байгууллагын Олон Улсын Стандарт |
| ДОА | Дорнод аймаг |
| НА | Нийцлийн аудит |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| СТА | Санхүүгийн тайлангийн аудит |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |

## 1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2025.02.18 № 129

танай ______ -ны № ______ -т

ДОРНОД АЙМГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА Б.ЭНХЭЭ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорнод аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

**Аудитын гол асуудал**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.2--д "Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны бүтэц, орон тоо, цалингийн санг Засгийн газраас тогтоосон хязгаарын хүрээнд Хурал өөрөө тогтооно.", ЗГ-ын 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 376 дугаар тогтоолын 1-д "Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийн тооноос хамааруулан ... ***Дорнод ... аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албыг 10***, ... хүртэл орон тоотой байхаар тус тус тогтоосугай" гэснийг хэрэгжүүлэн ажиллаагүй байна

**Бусад асуудлын хэсэг**

Дорнод аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал нь 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 36 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дарга 98.5 хувиар дүгнэсэн байна.

011021946

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 22,005,300.00 | 32,629,710.00 |
| 33 | АВЛАГА | 5,678,300.00 | - |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | 5,678,300.00 | - |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 16,327,000.00 | 32,629,710.00 |
| 354 | Хангамжийн материал | 16,327,000.00 | 32,629,710.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 183,000.00 | 290,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 638,000.00 | 16,833,710.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 15,506,000.00 | 15,506,000.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 92,043,460.09 | 112,074,205.58 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 92,043,460.09 | 112,074,205.58 |
| 392 | Биет хөрөнгө | 91,199,710.09 | 111,605,455.58 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 32,340,000.00 | 32,340,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (11,678,333.42) | (17,068,333.46) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 36,506,330.00 | 64,803,830.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (20,875,329.76) | (29,202,479.36) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 50,502,933.00 | 68,751,933.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (12,040,889.73) | (21,175,494.64) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 16,445,000.00 | 16,445,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | - | (3,288,999.96) |
| 393 | Биет бус хөрөнгө | 843,750.00 | 468,750.00 |
| 39301 | Програм хангамж | 1,500,000.00 | 1,500,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (656,250.00) | (1,031,250.00) |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 114,048,760.09 | 144,703,915.58 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 5,678,300.00 | - |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 5,678,300.00 | - |
| 413 | Өглөг | 5,678,300.00 | - |
| 4136 | Бусад өглөг | 5,678,300.00 | - |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 5,678,300.00 | - |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 108,370,460.09 | 144,703,915.58 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 108,370,460.09 | 144,703,915.58 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 60,169,756.83 | 60,169,756.83 |
| 51101 | Өмч: - төрийн | 60,169,756.83 | 60,169,756.83 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 44,777,435.26 | 81,110,890.75 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (17,184,774.69) | 44,777,435.26 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 61,962,209.95 | 36,333,455.49 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 3,423,268.00 | 3,423,268.00 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 114,048,760.09 | 144,703,915.58 |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **3,056,640,250.00** | **1,295,076,810.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **76,343,250.00** | **60,524,310.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 76,343,250.00 | 60,524,310.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 76,343,250.00 | 60,524,310.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 76,343,250.00 | 60,524,310.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,980,297,000.00** | **1,234,552,500.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 2,236,478,600.00 | 288,678,300.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 2,236,478,600.00 | 285,678,300.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 3,000,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 743,818,400.00 | 945,874,200.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт | 743,818,400.00 | 945,874,200.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **2,988,999,740.05** | **1,258,743,354.51** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,988,999,740.05** | **1,258,743,354.51** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 2,952,335,301.10 | 1,147,227,178.82 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 350,844,313.38 | 480,997,482.71 |
| 210101 | Үндсэн цалин | 203,007,381.01 | 252,858,746.71 |
| 210102 | Нэмэгдэл | 106,975,245.51 | 191,813,836.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 14,854,999.86 | 18,070,000.00 |
| 210104 | Урамшуулал | 26,006,687.00 | 18,254,900.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 43,911,009.67 | 59,754,329.60 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 30,870,182.67 | 41,070,623.60 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,628,259.00 | 4,820,912.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,802,934.00 | 2,403,956.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 594,956.00 | 2,291,887.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,014,678.00 | 9,166,951.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 25,535,780.00 | 21,039,505.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,922,000.00 | 3,220,500.00 |
| 210402 | Түлш, шатахуун | 16,000,000.00 | 15,996,988.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,515,480.00 | 1,542,017.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 398,300.00 | 280,000.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 4,700,000.00 | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 7,480,235.00 | 6,449,100.00 |
| 210604 | Урсгал засвар | 7,480,235.00 | 6,449,100.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 17,909,600.00 | 16,545,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 17,909,600.00 | 16,545,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 254,269,428.00 | 227,766,257.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 254,139,410.00 | 227,275,489.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 74,250.00 | 75,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 33,768.00 | 33,768.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 22,000.00 | 22,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 360,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 2,252,384,935.05 | 334,675,504.51 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,226,822,000.00 | 292,473,800.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 13,859,895.00 | 15,685,950.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 11,703,040.05 | 26,515,754.51 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 36,664,438.95 | 111,516,175.69 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 30,665,925.00 | 84,610,948.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 28,805,925.00 | 41,071,198.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | - | 42,189,750.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,860,000.00 | 1,350,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 5,998,513.95 | 26,905,227.69 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 5,998,513.95 | 26,905,227.69 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **67,640,509.95** | **36,333,455.49** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **67,640,509.95** | **36,333,455.49** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 2,974,618,700.00 | 1,234,552,500.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 2,974,618,700.00 | 1,234,552,500.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 2,230,800,300.00 | 288,678,300.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 2,230,800,300.00 | 285,678,300.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 3,000,000.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 743,818,400.00 | 945,874,200.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 743,818,400.00 | 945,874,200.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 2,968,940,400.00 | 1,234,552,500.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 2,968,940,400.00 | 1,234,552,500.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 2,932,275,961.05 | 1,123,036,324.31 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 350,844,313.38 | 480,997,482.71 |
| 210101 | Үндсэн цалин | 203,007,381.01 | 252,858,746.71 |
| 210102 | Нэмэгдэл | 106,975,245.51 | 191,813,836.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 14,854,999.86 | 18,070,000.00 |
| 210104 | Урамшуулал | 26,006,687.00 | 18,254,900.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 43,911,009.67 | 59,754,329.60 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 30,870,182.67 | 41,070,623.60 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,628,259.00 | 4,820,912.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,802,934.00 | 2,403,956.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 594,956.00 | 2,291,887.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,014,678.00 | 9,166,951.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 21,018,780.00 | 21,266,505.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,105,000.00 | 3,247,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 16,000,000.00 | 15,996,988.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,515,480.00 | 1,622,017.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 398,300.00 | 400,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 8,242,135.00 | 6,449,100.00 |
| 210604 | Урсгал засвар | 8,242,135.00 | 6,449,100.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 17,909,600.00 | 16,545,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 17,909,600.00 | 16,545,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 249,668,228.00 | 228,720,757.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 249,538,210.00 | 228,229,989.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 74,250.00 | 75,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 33,768.00 | 33,768.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 22,000.00 | 22,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 360,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,240,681,895.00 | 309,303,150.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,226,822,000.00 | 293,617,200.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 13,859,895.00 | 15,685,950.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 36,664,438.95 | 111,516,175.69 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 30,665,925.00 | 84,610,948.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 28,805,925.00 | 41,071,198.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | - | 42,189,750.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,860,000.00 | 1,350,000.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 5,998,513.95 | 26,905,227.69 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 5,998,513.95 | 26,905,227.69 |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | - | - |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | - |

## 4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | 2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 60,169,756.83 | 3,423,268.00 | -17,184,774.69 | 46,408,250.14 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 60,169,756.83 | 3,423,268.00 | -17,184,774.69 | 46,408,250.14 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 61,962,209.95 | 61,962,209.95 |
| C08 | 2023оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 60,169,756.83 | 3,423,268.00 | 44,777,435.26 | 108,370,460.09 |
| D01 | 2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 60,169,756.83 | 3,423,268.00 | 44,777,435.26 | 108,370,460.09 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 60,169,756.83 | 3,423,268.00 | 44,777,435.26 | 108,370,460.09 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 36,333,455.49 | 36,333,455.49 |
| D09 | 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 60,169,756.83 | 3,423,268.00 | 81,110,890.75 | 144,703,915.58 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 945,874,200.00 | 918,968,972.31 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 945,874,200.00 | 918,968,972.31 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 856,968,200.00 | 834,358,024.31 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 497,775,000.00 | 480,997,482.71 |
| 210101 | Үндсэн цалин | 259,000,000.00 | 252,858,746.71 |
| 210102 | Нэмэгдэл | 199,900,000.00 | 191,813,836.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 18,875,000.00 | 18,070,000.00 |
| 210104 | Урамшуулал | 20,000,000.00 | 18,254,900.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 62,222,200.00 | 59,754,329.60 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 42,310,900.00 | 41,070,623.60 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,977,800.00 | 4,820,912.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,489,000.00 | 2,403,956.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,489,000.00 | 2,291,887.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 9,955,500.00 | 9,166,951.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 21,447,500.00 | 21,266,505.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,247,500.00 | 3,247,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 16,000,000.00 | 15,996,988.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,800,000.00 | 1,622,017.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 400,000.00 | 400,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 6,500,000.00 | 6,449,100.00 |
| 210604 | Урсгал засвар | 6,500,000.00 | 6,449,100.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 18,700,000.00 | 16,545,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 18,700,000.00 | 16,545,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 229,302,000.00 | 228,720,757.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний тө | 228,810,000.00 | 228,229,989.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 75,000.00 | 75,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 35,000.00 | 33,768.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 22,000.00 | 22,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 360,000.00 | 360,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 21,021,500.00 | 20,624,850.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 5,301,100.00 | 4,938,900.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 15,720,400.00 | 15,685,950.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 88,906,000.00 | 84,610,948.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 88,906,000.00 | 84,610,948.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 42,200,000.00 | 41,071,198.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 44,706,000.00 | 42,189,750.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,000,000.00 | 1,350,000.00 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 945,874,200.00 | 918,968,972.31 |
| 1320 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 945,874,200.00 | 918,968,972.31 |
| 122005 | Орон нутгийн төсвөөс | 945,874,200.00 | 918,968,972.31 |
| 65 | ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ | 13 | 14 |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 8 | 8 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 4 | 5 |
| 650011 | Улс төрийн албан хаагч (УТ) | 1 | 1 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - |
| I | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 2,225,122,000.00 | 288,678,300.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 2,225,122,000.00 | 288,678,300.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 2,225,122,000.00 | 288,678,300.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,225,122,000.00 | 288,678,300.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,225,122,000.00 | 288,678,300.00 |
| II | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 2,225,122,000.00 | 288,678,300.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 2,225,122,000.00 | 288,678,300.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 2,225,122,000.00 | 285,678,300.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 3,000,000.00 |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 136.6 мянган төгрөгийн 5 зөрчил[1] илэрснээс, 0.8 сая төгрөгийн 1 төлбөрийн акт, 114.6 сая төгрөгийн 3 албан шаардлага, Орон нутгийн сонгуулийн үр дүнд чөлөөлөгдсөн албан тушаалтанд олгох 21.2 сая төгрөгийн тэтгэмжийг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулж ажиллах 1 зөвлөмж өгсөн.

### 3.1 Төлбөрийн акт

Монгол Улсын Их Хурлын 2007 оны 73 дугаар тогтоолыг зөрчин төрийн үйлчилгээний ажилтанд 0.8 сая төгрөгийн онцгой нөхцөлийн нэмэгдэл олгосон нь санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### 3.2 Албан шаардлага

1. Төлөөлөгчдийн 100.0 сая төгрөгийн зарцуулалтын ажлын тайлан байхгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
2. Орон тоог Сангийн яамны хянасан дүнгээс 3 орон тоогоор хэтрүүлэн төлөвлөсөн байна. Энэ нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.2-д "Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны бүтэц, орон тоо, цалингийн санг Засгийн газраас тогтоосон хязгаарын хүрээнд Хурал өөрөө тогтооно.", ЗГ-ын 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 376 дугаар тогтоолын 1-д "Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийн тооноос хамааруулан ... Дорнод ... аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албыг 10, ... хүртэл орон тоотой байхаар тус тус тогтоосугай" гэснийг зөрчсөн байна.
3. Өмнөх аудитын шийдвэрийг бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүйд албан шаардлага хүргүүлэх.

### 3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

_Илрүүлэлт:_ Орон нутгийн сонгуулийн үр дүнд чөлөөлөгдсөн аймгийн ИТХ-ын даргад Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.1-д "Аймаг, сум, нийслэл, дүүргийн Хурлын дарга болон бүх шатны Засаг дарга ээлжит сонгуулийн дүнд албан тушаалаасаа чөлөөлөгдсөн бол тэдгээрт урьд нь эрхэлж байсан албан тушаалын зургаан сарын цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэмж олгоно." гэж заасны дагуу тэтгэмжийг бодож олгоогүй байна.

_Өгсөн зөвлөмж:_ Орон нутгийн сонгуулийн үр дүнд чөлөөлөгдсөн албан тушаалтанд олгох тэтгэмжийг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулж ажиллах зөвлөмж өгөх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасны дагуу "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

төрийн аудитын байгууллагад ирүүлнэ". Харин зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 6 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс: Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Монгол Улсын Их Хурлын 2007 оны 73 дугаар тогтоолыг зөрчин төрийн үйлчилгээний ажилтанд онцгой нөхцөлийн нэмэгдэл олгосон байна. | 1 | 820.8 | 1 | 820.8 | - | - | - | - | - | - | - | - |
| Төлөөлөгчдийн зарцуулалтын ажлын тайлан байхгүй байна. | 1 | 100,000.0 | - | - | 1 | 100,000.0 | - | - | - | - | - | - |
| Орон тоог Сангийн яамны хянасан дүнгээс 3 орон тоогоор хэтрүүлэн төлөвлөсөн | 1 | 0.0 | - | - | 1 | 0.0 | - | - | - | - | - | - |
| Өмнөх аудитын шийдвэрийг бүрэн хэрэгжүүлээгүй | 1 | 14,555.9 | - | - | 1 | 14,555.9 | - | - | - | - | - | - |
| Орон нутгийн сонгуулийн үр дүнд чөлөөлөгдсөн албан тушаалтанд олгох тэтгэмжийг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулж ажиллах | 1 | 21,213.4 | - | - | - | - | 1 | 21,213.4 | - | - | - | - |
| **Дүн** | **5** | **136,589.2** | 1 | 820.8 | 3 | 114,555.0 | 1 | 21,213.4 | - | - | - | - |

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР
АКТ

2025 оны 02 сарын 18 өдөр Дугаар 03/А0160305 Чойбалсан хот

20А-2025/157/НА-СТА-ПЦЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дорнод аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төрийн үйлчилгээний ажилтанд 0.8 сая төгрөгийн онцгой нөхцөлийн нэмэгдэл олгосон нь Монгол Улсын Их Хурлын 2007 оны 73 дугаар тогтоолыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-д *"Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно."*, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.3-т *"цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон"* гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Буруу тооцож олгосон 820,800.00 /найман зуун хорин мянга найман зуун/ төгрөгийг Дорнод аймгийн Төрийн сан банкин дахь орон нутгийн хүү торгуулийн орлогын 100070000952 тоот дансанд төвлөрүүлэх.

2. Төлбөрийн актын биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Дорнод аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн дарга Б.Энхээ, нягтлан бодогч Ж.Батгэрэл нарт хариуцуулав

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН

АХЛАХ АУДИТОР Д.НАРМАНДАХ

2117144008
ХТУ4037 9030891

011050397

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 18 өдөр Дугаар 02/А1160305 Чойбалсан хот

ДОА-2025/157-НА-СТА-ТЧЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дорнод аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчдөд олгосон 100.0 сая төгрөгийн зарцуулалтын ажлын тайлан байхгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.1 дэх “*нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй;*” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төлөөлөгчдийн зарцуулалтын ажлын тайланг гаргуулан авах, биелэлтийг 2025 оны 05 дугаар сарын 24-ний дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулан ажиллахыг Дорнод аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн дарга Б.Энхээ, нягтлан бодогч Ж.Батгэрэл нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АХЛАХ АУДИТОР Д.НАРМАНДАХ

011041472

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 18 өдөр Дугаар 03/А1160305 Чойбалсан хот

ДОА-2025/157/НА-СТА-ТӨХ3

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дорнод аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Орон тоог Сангийн яамны хянасан дүнгээс 3 орон тоогоор хэтрүүлэн төлөвлөсөн байна. Энэ нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.2-д "Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны бүтэц, орон тоо, цалингийн санг Засгийн газраас тогтоосон хязгаарын хүрээнд Хурал өөрөө тогтооно.", ЗГ-ын 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 376 дугаар тогтоолын 1-д "Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийн тооноос хамааруулан ... Дорнод ... аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албыг 10, ... хүртэл орон тоотой байхаар тус тус тогтоосугай" гэснийг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11 дэх "*хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал*" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Орон тоог Засгийн газрын тогтоол, төсвийн хязгаарт багтаан батлуулах, биелэлтийг 2025 оны 12 дугаар сарын 10-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Засгийн газрын тогтоол, төсвийн хязгаарыг мөрдөн ажиллахыг Дорнод аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн дарга Б.Энхээ, нягтлан бодогч Ж.Батгэрэл нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АХЛАХ АУДИТОР Д.НАРМАНДАХ

2117144066
ХТҮ4037 9030091

011041475

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 18 өдөр Дугаар 04/А1160305 Чойбалсан хот

ДОА-2025/157/НА-СТА-ТУЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дорнод аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх аудитын шийдвэрийг бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.10 дэх "*аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол*" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн актыг бүрэн барагдуулах, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 20-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Аудитын шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллахыг Дорнод аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн дарга Б.Энхээ, нягтлан бодогч Ж.Батгэрэл нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АХЛАХ АУДИТОР Д.НАРМАНДАХ

2117144066
ХТҮ4037 9030891

011041479